



СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН  
САЛБАР ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2019 оны 04 сарын 12 өдөр

Дугаар 04

Сүхбаатар

Ажлын хэсэг томилох тухай

Монгол Улсын Төрийн албаны тухай хуулийн 75 дугаар зүйлийн 75.3, Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.3, 7.1.6, 13 дугаар зүйлийн 13.1.3 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1.Тус аймгийн Баянгол сумын иргэн Д.Ууганмаагаас “Сонгон шалгаруулалтын тухай” Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлд хандсан өргөдлийг магадлан шалгах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй томилсугай. Үүнд:

Ажлын хэсгийн ахлагч:

Э.Оюунболд

-Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын нарийн бичгийн дарга, Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн гишүүн

Гишүүд:

М.Нямсүрэн


-Шүүхийн Тамгын газрын дарга, Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн гишүүн

Б.Мөнхзул

-Аймгийн Шүүхийн шийдвэр гүйцэтгэх албаны дарга, Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн гишүүн

2.Өргөдөл гомдлыг зохих журмын дагуу шалгаж, дүгнэлт, санал боловсруулан Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн хуралдаанаар 2019 оны 04 дүгээр сарын 22-ны дотор танилцуулахыг ажлын хэсгийн ахлагч, Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын нарийн бичгийн дарга /Э.Оюунболд/-д үүрэг болгосугай.

ДАРГА



Ө.СУВДАА